

I. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.Тусгаар тогтносон, бүрэн эрхт Монгол Улс нь торийн байгууламжийн хувьд нэгдмэл, ардчилсан ёс, хvний эрх, эрх чолоо, чолоот эдийн засгийг эрхэмлэсэн улс богоод улс тор, газар зvйн хувьд Ази тивд хоёр их гvрний дунд оршдог, далайд гарцгvй, хогжиж байгаа орон юм. Монгол Улсын гадаад бодлого нь тус улсын Үндсэн хуульд тодорхойлон заасан үндэсний ашиг сонирхолд тулгуурлах богоод Монгол Улсын гадаад, дотоод овормоц байдал нь гадаад бодлогын зорилго, зарчим, чиглэлийг тодорхойлох үндэс болно.

2.Монгол Улсын гадаад бодлогын зорилт нь тус улс хvн торолхтний хогжлийн жамыг даган бvх улс оронтой найрсаг харилцаатай байж, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжvүлэн, бvс нутгийн болон дэлхийн нолоо бvхий улс гvрнvүдтэй улс тор, эдийн засгийн болон бусад ашиг сонирхлын шvтэлцээ бvхий харилцааны сvлжээ бүрдvүлэх замаар улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бат найдвартай хангах явдал мон.

3.Монгол Улс нээлттэй, эвсэлд vл нэгдэх бодлого явуулна. Ондор хогжилтэй улсуудын бодит сонирхлыг Монголд бий болгох бодлого баримтлахын хамт аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байдалд орохоос сэрэмжилнэ. Гадаад орнууд дахь Монголын сонирхлыг улс тор-эрх зvйн аргаар бататган хамгаална.

4.Монгол Улсын гадаад бодлогыг тодорхойлохдоо олон улсын харилцааны хогжил, дэлхий дахины болон бvс нутгийн улс торийн байдалтай нягт уялдуулж тэргvүлэх чиглэл, зорилтыг нь тогтоохдоо уян хатан хандаж байна.

5.Монгол Улсын аюулгvй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг улс тор-дипломатын аргаар хангах, эдийн засаг, шинжлэх ухаан-технологийг хогжvүлэх гадаад таатай ноцолойг бүрдvүлэх явдал гадаад бодлогын тэргvүлэх чиглэл байна.

6.Улс тор, эдийн засаг, шинжлэх ухаан-технологи, соёл хvмvүнлэгийн хvрээний гадаад харилцааны бодлого дотроос улс торийн гадаад бодлого тодорхойлогч шинжтэй байна.